



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/103.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багийн төвийн тоног төхөөрөмж /Жаргалант сум, Алагтолгой баг/ нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч "Монголиан каттл" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Т.Алимаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Нямсүрэн - Жаргалант сумын Алагтолгой багийн Засаг дарга

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батторж - Архивын тасгийн дарга

З.Эрхбаяр - "Монголиан каттл" ХХК-ны захирал

Нарийн бичгийн дарга: Ц.Энхтайван - Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн

2. Багийн төвийн тоног төхөөрөмж /Жаргалант сум, Алагтолгой баг/ нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч "Монголиан каттл" ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Туулайтулга /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02.0724
D/Zah-A/103-Bo